

**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ, ДОКТОР Л. ХАЙСАНДАЙ ТАНАА**

Танай хүрээлэнгийн 40 жилийн ойг тохиолдуулан Танд болон танай хамт олон, эрдэмтэн судлаачид, тус хүрээлэнд ажиллаж байсан үе үеийн ахмадуудад Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны хамт олны өмнөөс болон хувиасаа баярын халуун мэндчилгээ дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, эрдмийн дээдийг хүсэн ерөөж байгааг минь хүлээн авна уу.

40 жилийн тэртээ ШУА-д Дорно дахины хүрээлэн байгуулагдсан нь тухайн үеийн төр, засгаас олон улс, Дорно дахин судлалыг урагшлуулан хөгжүүлэхэд чиглүүлэн авч хэрэгжүүлсэн дорвитой арга хэмжээний нэг байсан билээ. Өнгөрсөн хугацаанд танай хүрээлэн, түүний эрдэмтэн мэргэдийн уйгагүй хөдөлмөрөөр бүтсэн хятад судлалын олон чухал бүтээл манай олон нийтийн сонирхлыг татаж ирсэн төдийгүй гадаад харилцаа, хамтын ажиллагааны мэргэжлийн байгууллагуудын залуу ажилтнуудад ч гарын авлага болж ирснийг манай дипломат, хятад судлаачид санаж явдгийг энд тэмдэглэе.

Эрдэмд оройгүй гэдэг. Эрдэм шинжилгээний ариун цагаан бөгөөд соён гэгээрүүлэх увдистай, тасралтгүй ундрах арвин ажилдаа нэгэн үзүүрт сэтгэлээр ханддаг та бүхэнд амжилтын дээдийг чин сэтгэлээсээ бэлгэдэн ерөөе !

Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд
Бүрэн эрхт Элчин Сайд Галсангийн Батсүх

2008 оны 6 дугаар сарын 17-ны өдөр
Бээжин хот